

Яамны дотоод асуудал, шагнал хариуцсан ахлах мэргэжилтэн, Мягмар Уранзул
2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Яамны үйл ажиллагааны өдөр тутмын тогтвортой, тасралтгүй байдлыг хангах, төрийн захиргааны байгууллага, харьяа байгууллагын болон салбарын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, манлайллаар хангах, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг, үйлчилгээ үзүүлнэ.							
1	Яамны хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангахад албан хаагчдад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.	1. Дотоод журмын хэрэгжилтийн биелэлтийн хувь 2. Гаргасан шийдвэрийн тоо	2024 оны гүйцэтгэл	Байгууллагын дотоод журмын хэрэгжилт сайжирсан байна.	Боловсролын яамны "Хөдөлмөрийн дотоод журам"-ын хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. 1.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай" А/89 дүгээр тушаалыг батлуулав. Зөвлөл нь Боловсролын яамны албан хаагчдын хүүхдийн хөгжлийг дэмжих, хүүхэд хамгааллын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг бүхийг Эцэг эхийн зөвлөл байна. 2.Албан хаагчдыг албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					шаардлагатай компьютер, техник, хэрэгслээр хангах, өрөө, тасалгааны засвар, үйлчилгээ, тохижилтод анхаарч холбогдох мэргэжилтнүүдтэй хамтарч, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Зардал батлах тухай А/27, А/88 дугаар тушаалаар 4 өрөөний засварыг хийж гүйцэтгүүлэв. 3.Албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглаглаж байсан тавилга шинэчлэх ажлыг Хөрөнгө оруулалтын хэлтэстэй хамтран зохион байгуулав. 85 албан хаагчийн тавилга шинэчилэх шаардлагатай байгаагаас эхний ээлжинд санхүүгийн гүйцэтгэлээр 31 албан хаагчдын тавилгыг шинэчлэв. 4.Мэдээллийн цагийн төлөвлөгөө батлуулан, хэрэгжилтийг зохион байгууллаа. 2025 оны эхний хагас жилд 10 удаагийн мэдээллийн цагийг хийв. 5.Албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд чиг үүргийн дагуу тухай бүр дэмжлэг үзүүлж ажиллав. 6.Хурлын танхим, заал, өрөөний захиалгын баталгаажилтыг хийн, хяналт тавьж ажиллаа. 7.Нэгжийн дарга нар болон албан хаагчдийн түр эзгүйд	
--	--	--	--	--	--	--

					бие биеэ орлон ажиллах хуваарийг нэгжүүдээс санал авч батлуулав. 8.Засгийн газрын 2024 оны "Хуулийн биелэлтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 164 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсролын яамны албан хаагчдын ажлын өдөр зайнаас ажиллах хуваарийг нэгтгэн танилцуулав. Хавсралт: 23 файл		
2	Салбарын шагнал урамшууллын бодлого, зохицуулалтыг зохион байгуулах, сан бүрдэлтэд хяналт тавих	Шагналын сангийн мэдээллийн хувь, хэмжээ, олгосон шагналын тоо, тушаал шийдвэрийн тоо	2024 оны гүйцэтгэл	Шагнагдсан албан хаагчдын мэдээллийг шагналын сангийн мэдээлэлд оруулсан байна.	Боловсролын сайдын 2024 оны Журам шинэчлэн батлах тухай А/28 дугаар тушаалаар батлагдсан "Боловсролын салбарын албан хаагчид шагнал олгох журам"-ын дагуу шагналыг шийдвэрлүүлэн, хүргүүлэх ажлыг зохион байгууллаа. Боловсролын сайдын 2025 оны А/170 дугаар тушаалаар.115 Боловсролын тэргүүний ажилтан, 98 Боловсролын жуух бичиг, Боловсролын сайдын 2025 оны А/278 дугаар тушаалаар 227 Боловсролын тэргүүний ажилтан, 253 Боловсролын жуух бичиг, 83 Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч тус тус олгосон байна. Шагнагдсан албан хаагчдын мэдээллийн журмын дагуу Боловсролын ерөнхий газарт	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хүргүүлэх, шалгах, нэгтгэх ажлыг гүйцэтгэв.		
3	Албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх журам боловсруулж батлуулах;	Батлагдсан журам	-	Журам батлагдсан байна.	"Боловсролын яамны албан хаагчид орон сууц худалдан авах, орон сууцны нөхцөл сайжруулахад зориулсан санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын төслийг боловсруулан нэгжийн удирдлагад танилцуулав. Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралд танилцуулахаар хүлээж байна.	6-р сар	Өөрийн үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
4	"Мэдээллийн цаг"- зохион байгуулах төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах;	"Мэдээллийн цаг" - ийн тоо, хамрагдсан албан хаагчдын хувь	2024 оны гүйцэтгэл	Яамны "Мэдээллийн цаг"-ийн эхний хагас жилийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Яамны албан хаагчдын мэдээллийн цагийн эхний хагас жилийн төлөвлөгөө батлуулан, хэрэгжилтийг ханган зохион байгуулалтыг хийв. Нэгжүүд батлагдсан хуваарийн дагуу хамтран ажиллав. Дараах сэдвийн хүрээнд 10 удаагийн мэдээллийн цаг хийсэн байна. 1."365 программын хэрэглээний талаар" - ТЗУГ 2."Их өгөгдөлд суурилсан боловсролын бодлого, төлөвлөлт" - П.Оюунаа /Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга/ 3."Төрийн чадамжийг бүрдүүлэх нь" -	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					Б.Дөлгөөн /Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал/ 4."Төрийн албан дахь ёс зүйн боловсрол, харилцаа хандлагыг эерэгжүүлэх техник оролцоонд тулгуурласан сургалт"- Р.Лхагвадулам /Имако институтийн захирал/ 5."Боловсролын хувирган өөрчлөлт" - Ц.Дэмбэрэл /Монголын ирээдүй судлалын нийгэмлэгийн тэргүүн/ 6."Хиймэл оюун, технологийн хувьсгал" - Ц.Эрдэнэбат /Эдийн засаг хөгжлийн яамны нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга/ 7."Хувь хүн, байгууллагын кибер аюулгүй байдал" - Кибер гэмт Хэрэгтэй тэмцэх газрын Тоон ул мөр илрүүлэх хэлтсийн ахлах мөрдөгч ахлах дэслэгч 3.Төрболд, Кибер гэмт Хэрэгтэй тэмцэх газрын Тоон ул мөр илрүүлэх хэлтсийн ахлах мөрдөгч ахлах дэслэгч Э.Пүрэв-Очир 8."Хөрөнгө оруулалт ба хөрөнгийн зах зээлийн тухай" - Ё.Амарбат /Стоклаб секьюритиз ҮЦК" ХХК-ийн гүйцэтгэх захирал/ 9."Ажлын байрны ёс зүй" - Д.Ерөө /Юнайтед менежмент консалтинг, захирал/ 10."Орон нутгийн хамгаалалтын тухай хууль болон Дайчилгааны тухай	
--	--	--	--	--	---	--

					хуулийн хэрэгжилтийн талаар" Батлан хамгаалах яамны холбогдох албан хаагчид Албан хаагчдын оролцоо 90 хувь байв. Хавсралт: 7 файл			
5	Яамны хүндэтгэлийн танхим болон хурал, уулзалтын өрөөний цагийн хуваарь гаргах зохион байгуулалтыг хийнэ.	Зохион байгуулагдсан хурал уулзалт	2024 оны гүйцэтгэл	Уулзалт, өрөөний хуваарь	хурлын цагийн	Боловсролын яамны хүндэтгэлийн танхим, хурал, уулзалтын өрөөний захиалгыг эйбл системийн захиалга цэсэд оруулах ажлыг зохион байгуулав. Ингэснээр албан хаагчдад өрөөний захиалга нээлттэй болсноор хурал, уулзалтын цаг давхардахгүй байх, хаана, ямар уулзалт, хурал болж байгаа талаар мэдээлэл нээлттэй байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 111 тоот хурлын өрөөнд 101 удаагийн хурал, уулзалт, 400А буюу зааланд 79 хурал, 400Б хурлын танхимд 65 удаагийн хурал тус тус зохион байгуулагдсан байна. Тус хурал, уулзалтын өрөө, хурлын заалны цэвэрлэгээ үйлчилгээ, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд анхаарч ажиллав. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
6	Яамны албан хаагчдын цаг бүртгэлд хяналт тавьж, мэдээг	Цаг бүртгэлийн мэдээ	-	Албан хаагчдын цаг бүртгэлийн мэдээг улирал тутам гаргаж, нэгжийн даргад	Албан хаагчдын цаг бүртгэлийн төхөөрөмжийг шинэчлэх ажлыг холбогдох мэргэжилтэнтэй хамтран	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн	

	нэгжийн даргад улирал тутамд гаргаж өгнө.			хүргүүлсэн байна.	хийж гүйцэтгэв. Албан хаагчийн ажлын цаг бүртгэлийг биеийн дулаанаар мэдэрдэг төхөөрөмжөөр бүртгэх, бүртгэлийг шинэчлэх, мэдээллийг татах, хянах ажлыг гүйцэтгэв. Цаг бүртгэлийн мэдээллийг сард 2 удаа нэгжүүдээс татан авч, нэгжийн даргаар нь баталгаажуулан яамны нягтланд хүлээлгэн өгөх, нийт албан хаагчдын цагийн бүртгэлийг нэгжийн даргад танилцуулах ажлыг хийв. Хавсралт: 2 файл		даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
7	Боловсролын яамны ахмадын хороо болон Монголын ахмад багш нарын холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Тушаал, шийдвэр, зохион байгуулагдсан арга хэмжээ	2024 оны гүйцэтгэл	Үйл ажиллагааны төлөвлөгөө болон зардлын тушаал батлуулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлнэ.	Боловсролын яамны Ахмадын хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллахад шаардагдах төсвийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/23 дугаар тушаалаар батлуулав. Яамны удирдлагаас яаманд ажиллаж байсан ахмадуудын ая тухтай байдлыг хангах зорилгоор яаманд өрөө гарган, шаардлагатай тохижилтыг хийж, дэмжлэг үзүүллээ. Мөн Цагаан сарын баярын өдрийг тохиолдуулан ахмадуудад хүндэтгэл үзүүлэв. Боловсролын яам, ухааны яам, Монголын ахмад багш нарын холбоо	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хамтран 2025 оны үйл ажиллагааны гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг батлав. Монголын ахмад багш нарын холбооноос төрийн одон медалиар шагнуулахад дэмжлэг хүссэн ахмад багш нарын шагналыг материалыг журмын дагуу ЗГХЭГ-т уламжлав. Хавсралт: 1 файл		
8	Салбарын шагналын тэмдэг, үнэмлэх, жуух хэвлүүлэх төсвийн төслийг боловсруулж батлуулах, хэвлүүлэх ажлыг зохион байгуулна.	Боловсролын салбарын тэргүүний тэмдэг, үнэмлэх, жуух, хавтас	2024 оны гүйцэтгэл	Боловсролын салбарын тэргүүний үнэмлэх болон жуух хэвлүүлэх тушаал боловсруулж, батлуулсан байна. Салбарын тэргүүний үнэмлэх, жуухыг хэвлүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	Боловсролын сайдын 2025 оны "Зардал батлах тухай" А/119 дүгээр тушаалаар Боловсролын салбарын тэргүүний ажилтны хүндэт тэмдэг, үнэмлэх, хавтас үйлдвэрлэн нийлүүлэхэд шаардагдах зардлыг батлав. Энэ тушаалын хэрэгжилтийн хүрээнд Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Үнэлгээний хороо байгуулах тухай" А/85 дугаар тушаалаар Салбарын тэргүүний ажилтны тэмдэг, үнэмлэх, яамны жуух бичиг, хавтас үйлдвэрлэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулав. Үнэлгээний хорооны сонгон шалгаруулалтын шийдвэрийн дагуу гүйцэтгэгчтэй гэрээ	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					байгуулж, салбарын шагналын тэмдэг, үнэмлэх, хавтас нийлүүлэх ажлыг эхлээд байна. Хавсралт: 2 файл		
9	Монгол Улсын цол, төрийн одон медальд нэр дэвшигчдэд төрийн захиргааны байгууллагаас санал өгөх ажлыг зохион байгуулна.	Салбарын байгууллага, болон яамны албан хаагчдыг шагналд тодорхойлон ЗГХЭГ-т, аймаг, нийслэлийн Засаг даргад /Төрийн дээд шагналд дэмжиж/ хүргүүлсэн албан бичгийн тоо, шийдвэрлэлтийн хувь	2024 оны гүйцэтгэл	ЗГХЭГ-аар уламжилсан тодорхойлолтын мөрөөр ажиллаж, Ерөнхийлөгчийн зарлигаар олгосон шагналыг гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулж, ЕТГ-т тайлангаа хүргүүлсэн байна. Аймаг, нийслэлийн Засаг даргын ирүүлсэн Төрийн дээд шагналд нэр дэвшигчдийн баримт бичгийг судалж, тухай бүр дэмжих эсэх талаар албан бичгээр хариу өгсөн байна.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оын 71 дүгээр Зарлигаар баталсан "Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам"-ын дагуу Боловсролын салбарын албан хаагчдыг Төрийн одон медалиар шагнуулахаар холбогдох байгууллагууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг судлан Ерөнхийлөгчийн тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт уламжлав. 2025 оны эхний хагас жилд Ерөнхийлөгчийн тамгын газарт 14 багш, ажилтан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 199 , нийт 213 багш, ажилтныг шагнуулахаар материалыг дээд байгууллагт уламжилсан байна. 17 дугаар жарны "Элдэв эрдэнэт" хэмээх могой жилийн цагаан сарын баярыг тохиолдуулан эрхэлсэн ажил, салбартаа олон жил үр бүтээлтэй ажиллаж онцгой амжилт гарган, эх орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					оруулж буй боловсролын салбарын ажилтан албан хаагчдад Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Төрийн одон медаль гардуулах ёслолын ажиллагааг 2025 оны 02 дугаар сарын 24-ны өдөр Боловсролын яаман дээр зохион байгуулав. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон - 10 , Алтан гадас одон-32, Хөдөлмөрийн хүндэт медаль-25 иргэнийг тус тус шагнав. Шагналыг Боловсролын сайд гардуулсан.		
10	Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хүсэлт гаргасан Улсын цол, төрийн одон медальд нэр дэвшигчдийн мэдээллийн санг бий болгоно.	Мэдээллийн сан	2024 оны гүйцэтгэл	Төрийн одон медальд санал өгсөн иргэдийн сангийн баяжилт хийж, 2025 оны эхний хагас жилийн нийт тоог гаргасан байна.	Боловсролын салбараас Төрийн одон медальд нэр дэвшүүлэн ирүүлсэн албан хаагчдын бүртгэлийг хийж, мэдээллийн санд оруулав. 2025 оны эхний хагас жилд харьяа байгууллагуудаас Боловсролын салбарын 213 ажилтан, албан хаагчдын шагнуулах хүсэлт ирүүлснийг бүртгэл хийв. Монгол Улсын Ардын багш цолоор 6, Монгол Улсын Гавьяат багш цолоор 35, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 23, Алтан гадас одонгоор 62, Хөдөлмөрийн хүндэт медалиар 87 тус тус иргэний материалыг шалган дээд байгууллагад	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					уламжилсан. ,		
11	Салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах асуудлын хэрэгжилтийг хариуцан ажиллах	Төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	2024 оны гүйцэтгэл	Хэрэгжилтийг ханган ажилласан байна.	1.Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 2025.03.26-ны өдрийн Лхагва гарагт яамны албан хаагчдад ОБЕГ-ын хэлтсийн дарга, хурандаа Д.Сэржмядаг ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДЛАА ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭ сэдвээр сургалт хийв. 2.2025.03.27-ны өдрийн Пүрэв гарагийн 16:00 цагт Орон даяар зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах дадлага сургуулилтыг Онцгой байдлын ерөнхий газрын холбогдох албан тушаалтнуудтай хамтран зохион байгуулав. 3.Батлан хамгаалах сайдын 2025 оны А/80 дугаар тушаалын дагуу батлан хамгаалах хууль тогтоомж, орон нутгийн хамгаалалтын тухай хууль болон Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийн талаар сургалтыг тус яамны холбогдох албан хаагчиддтай хамтран яам болон харьяа байгууллагын удирдлагуудын хүрээнд зохион байгуулав. Мөн яамны 18-50 насны	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					эрчүүдийн судалгааг авч, ирүүлсэн маягтын дагуу нэгтгэн Батлан хамгаалах яаманд хүргүүлэв. 4. Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан Гамшгаас хамгаалсан команд штабын дадлага, сургалтад 2025 оны 03 сарын 26-28-ны өдрүүдэд оролцов. 5.Боловсролын яамны 2025 оны Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний төслийг боловсруулав. Хавсралт: 4 файл		
3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
12	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Гүйцэтгэсэн ажлын тоо	2024 оны гүйцэтгэл	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдсан, эхний хагас жилийн биелэлтийг тайлагнасан, мэдээллийг цаг тухайд бэлтгэсэн байна.	өрийн албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан хугацаанд нь батлуулав. 2025 эхний хагас жилийн болон жилийн эцсийн тайланг хугацаанд нь хүргүүлэв.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
13	Архив, албан хэрэг	Хугацаанд нь	2024 оны	Албан бичиг,	2025 оны эхний хагас жилд	1-р сар, 2-	Өөрийн

	хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл гомдлын тоо	гүйцэтгэл	өргөдөл, санал хүсэлтийг журамд заасан хугацаанд хариу өгөх	удирдлагаас 186 албан бичиг цохогдон ирснээс 24 өргөдөл, санал хүсэлт байв. Салбарын шагналд тодорхойлж, шагнуулах хүсэлт ирүүлсэн байгууллагын албан тоотоос гадна иргэдээс ирүүлсэн өргөдлийн дийлэнх нь салбарын тэргүүний тэмдгээ гээсэн, нөхөж авах хүсэлтэй байгаагаа дурдсан байдаг. Салбарын тэмдэг нөхөн олгох журмын дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлэлтийг хангуулан, шийдвэрлэн ажиллав. Нийт 18 иргэнд салбарын тэмдэг нөхөн олгосон байна. Эхний хагас жилд 60 албан тоотыг холбогдох байгууллагуудад хариу хүргүүлсэн бөгөөд Харьяа байгууллагаас албан хаагчдаа Төрийн одон медальд нэр дэвшүүлж ирүүлсэн материалыг судлан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан журмын дагуу Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 39 албан тоотоор уламжилсан.	р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---	---	-----------	---	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
---	-----------------	---------------	---------

1	2	3	4
---	---	---	---

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Байгууллагын мэдээллийн цаг, бусад холбогдох сургалтад хамрагдана.	Цаг үеийн холбогдох сургалт болон байгууллагын мэдээллийн цагтад хамрагдана.	2024 оны гүйцэтгэл	Холбогдох сургалтад хамрагдсан байна.	1.Боловсролын яамнаас зохион байгуулсан 10 удаагийн Мэдээллийн цагт хамрагдав. 2.Монгол бичгийн сургалтад хамрагдав.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%
2	Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэх	Яамнаас зохион байгуулагдах монгол бичгийн сургалтад хамрагдана.	-	Сургалтад хамрагдсан байна.	Яамнаас зохион байгуулж байгаа Монгол бичгийн сургалтад хамрагдав.	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Яамны дотоод асуудал, шагнал хариуцсан ахлах мэргэжилтэн, Мягмар Уранзул /...../

Огноо: